



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ТОГТООЛ

1995 оны 3 дугаар

Улаанбаатар

сарын 9-ний өдөр  
67

Дугаар  
хот

ДЭЭД ШҮҮХИЙН БҮГД ХУРЛЫН 1991 ОНЫ  
13 ДУГААРТОГТООЛЫН 8 ДУГААР  
ЗҮЙЛИЙГ ӨӨРЧЛӨН НАЙРУУЛАХ ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг зүйлчилж байгаа шүүхийн практикийг нэг мөр болгож хуулийн заалтад нийцүүлэх зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Дээд шүүхийн Бүгд хурлын 1991 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 13 дугаар тогтоолын 8 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"8. Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлд заасан бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах хэрэг нь зөвхөн хулгайлах, завших, үрэгдүүлэх, албан тушаалынхаа байдлыг урвуулж ашиглаж залилан мэхлэх зэрэг аргаар үйлдэгдэж болно. Хэрэв бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, булаах, далайлган сүрдүүлэх аргаар ашиглан шамшигдуулсан бол уг хэргийг ашиглан шамшигдуулсан эд хөрөнгийн хэмжээнээс

хамаарахгүйгээр эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсгээр зүйлчилнэ.

Бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй /Дээд шүүхийн 1994 оны 125 дугаар тогтоолд заасан 3000-50000 төгрөг хүртэл/ ашиглан шамшигдуулах хэрэг нь урьдчилан тохиролцсон бүлэг этгээд онц аюултай гэмт хэрэгтэн, нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж буюу машин механизм ашиглаж, эсхүл орон байр, агуулах саванд хууль бусаар нэвтэрч үйлдсэнээс үл хамааран Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлийн дагуу зүйлчлэгдэнэ.

Харин удаа дараагийн үйлдлээр нэг эх үүсвэрээс эд хөрөнгө ашиглан шамшигдуулсан бол үргэлжилсэн гэмт хэрэг гэж үзэж учирсан хохирлын нийлбэр дүнгээр хэргийг зүйлчилнэ".

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН

ШҮҮГЧ

Д.БАТСАЙХАН